

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ТҮЙМЭРТ ШАТСАН ТАЛБАЙД ОЙЖУУЛАЛТЫН АЖИЛ ХИЙХ /БАЯН-УУЛ  
СУМ/ АЖЛЫН ДААЛГАВАР

2019.12.25



<p>Ойжуулалтын ажил гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулахад харгалзах үзүүлэлтүүд</p>	<p>Ажлын шалгуур үзүүлэлт</p>
	<p>“Мод үржүүлэх, ойжуулах, ойг нөхөн сэргээх” чиглэлээр мэргэжлийн байгууллагын эрхтэй, тарьц суулгацын нөөцтэй, ажлын туршлагатай аж ахуйн нэгж байна. /Ойн нөхөрлөлтэй түншилж болно/</p>
	<p>Ойжуулалтын ажил хийх мэргэжлийн боловсон хүчинтэй байх ба ойн инженер-1, ойн техникч-2, ойжуулагч-3 ба түүнээс дээш, энэ чиглэлийн ажлын дадлага туршлагатай ажилтнуудтай байна. /нотлох баримтаар баталгаажуулсан байх/</p>
	<p>Стандартын тарьц, суулгацны нөөцтэй байна. /тарьцын тоо, MNS:6140-2010 стандарт хангасныг актаар нотолсон байх бөгөөд нэг га талбайд чанарын 1 дүгээр зэргийн шилмүүст төрлийн модны стандартын шаардлага хангасан тарьц 2500 ширхэгээс доошгүйг тарих нөөцтэй/</p>
	<p>Өмнө жилүүдэд хийсэн ойжуулалтын ажил болон ижил төстэй бусад ажлын акт, тодорхойлолт, гэрээний хувийг хавсаргана.</p>
	<p>Тарьсан тарьц суулгацын амьдралтыг 3 жилийн хугацаанд арчлан ургуулах төлөвлөгөөг Сум дундын ойн ангиар батлуулсан байна</p>
	<p>Ойжуулалтын ажил хийх болон таримал ойг цаашид арчлах, хамгаалах талаар захирал болон ерөнхий инженерийн баталгаажуулсан технологийн карттай байна.</p>
<p>Бэлтгэл ажил</p>	<p>Газрын хөрс боловсруулах трактор, анжис мод тарих колесовын царил, жоотуу, хүрз, усалгааны емкость 2,5 тонн, усалгааны хоолойнууд зэрэг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжтэй байна.</p>
	<p>Ойжуулах ажлын технологийн картыг боловсруулж Сум дундын ойн ангиар хянуулсан байна.</p>
	<p>Ойжуулах талбайг өөрийн хөрөнгөөр цэвэрлэж бэлтгэн, ойн цэвэрлэгээний ажил хийгдсэн талбайд ойжуулалтын ажил хийсэн байна. Сум дундын ойн ангиар тусгаарлуулсан байх, өнцгүүдэд шон босгож, талбайд шан гаргаж, чиг тэмдэг тавьсан байна.</p>
	<p>Тарих тарьц суулгацыг ачих буулгах, түр хадгалах технологи, горим мөрдсөн байна.</p>
	<p>Түймэрт шатсан 50 га талбайд хөрсийг боловсруулж шан татах арга, технологи мөрдөж тарьцыг 30 см гүнд тарина. /Шангийн өргөн 40 см, гүн 30 см, шан хооронд 4 м байна/</p>
<p>Суулгах тарьцыг тарилтад бэлтгэн хавсралт зураг 1-д заасан тарилтын технологээр эгнээ хооронд 4 м, ургамал хооронд 1 метр зайтайгаар</p>	

Үндсэн ажил	тарина.
	Технологийн картын дагуу тарьц тарьж, усалж арчлан хамгаална
	Усалгааг хийж чийгийг барих арга хэмжээг авсан байна.
	Ойн ангийн инженер, Байгаль хамгаалагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагчаас арга зүйн заавар зөвлөгөө авч ажлыг гүйцэтгэсэн байна.
	Ойжуулах талбайд тарьц тарьсны дараах усалгааг системтэйгээр хийсэн байна.
	Анх тарьснаас хойш 3 жилийн турш гүйцэтгэгч аж ахуйн нэгж ургах чадваргүй болсон тарьц, суулгацыг авч, нөхөн тарилт хийж ургуулсан байна.
	Ойжуулсан талбайд мал бэлчээхийг хориглосон анхааруулга бүхий пайз 4 ширхэг, тендерт ажлын танилцуулга төмөр самбар 1 ширхэгийг бэлтгэж бетонон суурьт бэхэлж анхааруулах самбар, булангийн тэмдэгжүүлтийг журмын дагуу хийж байрлуулсан байна.
	Тарьсан ойг хүний сөрөг нөлөө, мал амьтны хөлөөс хамгаалах арга хэмжээ авч, мөн гал түймрээс хамгаалах шороон зурвас татна. /5-7м өргөнтэй тойруулан хагална/
	Ажлын үе шат бүрийг фото зураг, бичлэг хийж баталгаажуулан захиалагчид хүлээлгэн өгсөн байна.
Ойжуулалтын ажлын хувийн хэргийг хөтлөн, талбайн зургийн хамт ажил хүлээж авах комисст танилцуулсны дараа акт үйлдэнэ	

2020 онд ойжуулах талбайн зураглал

Google Earth

Image © 2019 CNES / Airbus

Ар дархинт /50 га/						
Д/д	Солбицол					
	Гр	Мн	Сек	Гр	Мн	Сек
1	49	14	20.18	112	21	37.3
2	49	14	30.22	112	21	53.14
3	49	14	23.89	112	23	13.84
4	49	14	14.18	112	23	2.85

**Legend**

○ ойжуулах талбай



3000 ft

